



**ОРХОН АЙМГИЙН
БҮСИЙН ОНОШИЛГОО,
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2026 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/24

Баян-Өндөр сум

“ Байгууллагын ажилтнуудад ажлын үр дүн, гүйцэтгэлээр нэмэгдэл хөлс олгох журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 2.6 дахь заалт, 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Удирдлагын зөвлөл, ажилчдын хамтарсан хурлын шийдвэр, 2026 оны 1 дүгээр сарын 15 өдрийн “Үр дүнгийн урамшуулал олгох журам”-ыг шинэчлэн батлах комиссын шийдвэр зэргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. БОЭТ-ийн албан хаагчдад ажлын үр дүн, гүйцэтгэлээр нэмэгдэл хөлс олгох журмыг нэгдүгээр, ур чадварын нэмэгдэл олгох, дүгнэх шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар, ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэх хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг 2026 оны нэгдүгээр улирлаас эхлэн мөрдөж, ажлыг үр дүн, гүйцэтгэлээр олгох нэмэгдэл хөлсийг үр дүнгийн урамшууллын зардлаас тооцон гаргахыг Санхүү бүртгэлийн албаны дарга (Н.Ариунзаяа)-д үүрэг болгосугай.

3. Тусламж үйлчилгээний чанар, ажлын сахилга бат, хариуцлага, ёс зүй, гүйцэтгэлийн санхүүжилтийг үр дүн гүйцэтгэлтэй уялдуулан дүгнэж ажиллахыг албадын дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ажилтан (А.Баярхүү)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Байгууллагын захирлын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/29 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ  Ц.НАРАН-ЭРДЭНЭ



612601151



БОЭТ-ИЙН АЛБАН ХААГЧДАД АЖЛЫН ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛЭЭР НЭМЭГДЭЛ
ХӨЛС ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1.Энэхүү журмаар тус эмнэлгийн ажиллагсдын албан тушаалын тодорхойлолтод тусгасан ажлын үр дүн, гүйцэтгэл, ёс зүйн хэм хэмжээг харгалзан мөнгөн урамшил олгох, гүйцэтгэлийг бодитой үнэлэх нэгдсэн аргачлалаар хангах харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Ажилтнуудад нэмэгдэл хөлс, урамшуулал олгохдоо хөдөлмөрийн тухай хууль, засгийн газрын тогтоол, хамтын гэрээ тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрхзүйн актуудыг удирдлага болгоно.

1.3.Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчдад олгоно.

1.4.Дэд захирал нарын ажлыг байгууллагын захирал, албадын дарга, тасгийн эрхлэгчийн нарын ажлын гүйцэтгэлийг эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, өөрийн тасгийн ажилчдыг тасгийн эрхлэгч нар тус тус үнэлнэ.

№	Үнэлгээ хийх албан тушаалтан	Үнэлгээ хийлгүүлэх тасаг алба, нэгжийн албан тушаалтан
1	Эмнэлгийн дарга	ЭЗЭДЗ, ТҮАЭДЗ
2	ЭЭДЗахирал	Албадын дарга нар, тархвар судлаач, тасгийн эрхлэгч нар
3	ЭМТҮЧАБ-ын албаны дарга	Чанарын ажилтан, Чанарын багийн ахлагч
4	ТҮАЭЗ	Инженер техникийн алба
5	Хүний нөөц, сургалт хөгжлийн албаны дарга	Хүний нөөцийн менежер, ажилтан, архивын эрхлэгч, бичиг хэргийн ажилтан, сургалт эрдэм шинжилгээ хариуцсан ажилтан
6	СБАДарга	Нягтлан бодогч, нярав,
7	Эрүүл мэндийн даатгал, статистик мэдээллийн албаны дарга	Эрүүл мэндийн даатгалын их эмч, ажилтан, статистикч эмч, бага эмч, эдийн засагч
8	Сувилахуйн алба	Тасгуудын ахлах сувилагч, аргазүйч, туслах сувилагч
9	Тасгийн эрхлэгч	Өөрийн тасгийн их эмч, сувилагч, үйлчлэгч, үйлчилгээний ажилчид

ХОЁР.УРАМШУУЛАЛ ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үр дүнгийн үндсэн шалгуур	Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Үндсэн шалгуурын оноо	
АЖИЛТАНД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ				
1	Үйлчилгээний чанар		25	
2	Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт	6	
3		Ажлын ачаалал	6	
4		Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт;	6	
5		Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал.	6	
6	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	Эрүүл мэндийн даатгалын хасагдлын хувь, эдийн засгийн үр өгөөжийг тооцсон байдал;	8	
7		Эмчилгээ үйлчилгээнд шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн чанар сайжруулах талаар санаачилгатай ажиллаж, үр дүнг тооцсон байдал;	8	
8		Ажлын идэвх, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал.	4	
ТУСГАЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ				
1	Эмнэлгийн мэргэжилтэн	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар	Эмчилгээ, үйлчилгээний стандартыг мөрдөж байгаа байдал;	8
2			Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал;	8
3			Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажилласан байдал	7
4			Үр дүнгийн гэрээ, Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар.	8
1	ЭМ-ийн бусад ажилтан	Хариуцсан ажлын чанар	Стандарт мөрдөж байгаа байдал;	10
2			Үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар;	10
3			Удирдлагын зүгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлт	11

ГУРАВ.УРАМШУУЛЛЫГ ДҮГНЭХ АРГАЧЛАЛ

3.1.“Үйлчилгээний чанар”-ын шалгуур үзүүлэлтийг дүгнэхдээ ёс зүй, эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар гаргасан өргөдөл, гомдлыг үндэслэн ямар нэгэн гомдол, харьцаа хандлага, мэргэжлийн ёс зүйн болон төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргаагүй ажилтанд 25 оноог өгөх ба гомдол харьцаа хандлагын зөрчил гаргасан бол оноог бүрэн хасна.

3.2.“Ажлын ачаалал, хариуцлага”-ын шалгуур үзүүлэлтийг дүгнэхдээ:

Ажлын цаг ашиглалтыг дүгнэхдээ Өвдөж, чөлөө аваагүй, ажил таслаагүй сарын турш ажилдаа бүрэн ирсэн бол ажлын цаг ашиглалтын 6 оноог бүрэн өгөх ба ажлын 1-7 хоног Өвчтэй, цалингүй чөлөө авсан бол 2 оноог, 7-14 хоног өвчтэй чөлөөтэй бол 4 оноог, 15-аас дээш хоногоор өвчтэй чөлөөтэй, оноог бүрэн хасаж тооцно. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил тасалсан бол тасалсан хоног тутамд 1 оноог тооцон хасна.

Ажлын ачааллыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний тоон ба чанарын үзүүлэлтээр дүгнэнэ. (Эмч нарыг сарын үзлэгийн тоо, Фонд ашиглалтын байдал, үйлчлэгч нэрт цэвэрлэгээ үйлчилгээний чанарын байдлыг харгалзан үзнэ.)

Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалтыг дүгнэхдээ тасаг нэгжид байгаа аппарат, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалтын байдалд тоног төхөөрөмжийн инженерийн өгсөн дүгнэлтээр хувь хүний буруутай үйлдлээр эвдэрсэн бол оноог бүрэн хасна. Тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортыг дутуу хөтөлсөн бол тал оноог хасаж тооцно.

Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдлыг дүгнэхдээ ЭМГ, ЭМЯ болон бусад газарт гарган өгдөг тайлан мэдээг хугацаанд нь гаргаж өгсөн бол 6 оноог, өгөөгүй бол оноог бүрэн хасах, Тайлан мэдээг хоцроосон, анхан шатны бичиг баримт, өвчний түүх, эмийн захиалгын хуудас, сувилагчийн тандалтын хуудсыг стандартын дагуу хөтлөөгүй бол оноог хасаж дүгнэнэ.

3.3. “Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь нэмэр”-ийн шалгуур үзүүлэлтийг дүгнэхдээ:

Эрүүл мэндийн даатгалын хасагдлын хувийг үнэлэхдээ тухайн улиралд даатгалын хасагдал 5-10% байвал 4 оноо, 10-15%-ын хасагдалтай бол 6 оноо, 15%-с дээш бол бүтэн оноо буюу 8 оноог хасаж тооцно.

Эмчилгээ үйлчилгээнд шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн чанар сайжруулах талаар санаачилгатай ажиллаж, үр дүнг тооцсон байдлыг дүгнэхдээ тасаг хамт олноороо улиралд 1 удаа эмчилгээ үйлчилгээнд шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн, үргүй зардлыг багасгасан ач холбогдолтой, чанар сайжруулах чиглэлээр далайцтай үр өгөөжтэй ажил санаачлан зохион байгуулсан бол оноог бүтэн олгох ба ач холбогдол, үр өгөөж багатай бол оноог хасаж тооцно.

Ажлын идэвх, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдлыг дүгнэхдээ ЭМГ, байгууллага, тасаг хамт олноос зохион байгуулсан олон нийтийн ажилд оролцсон байдлаар оноог хасаж тооцно.

3.4.“Эмнэлгийн мэргэжилтний тусгай шалгуур үзүүлэлтийг дүгнэхдээ эмчилгээ, үйлчилгээний стандарт болон халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хийсэн ажил, үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэлийн байдлыг дүгнэж гаргасан алдаа тутамд оноог хасаж тооцно.

3.5.“Эмнэлгийн бус ажилтны тусгай шалгуур үзүүлэлтийг дүгнэхдээ стандарт мөрдөлтийн байдал, үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэлийн байдал, байгууллага, тасгийн эрхлэгчээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн байдлыг дүгнэж тооцно.

ДӨРӨВ.УРАМШУУЛАЛ ОЛГОХ НӨХЦӨЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Бүх шалгуурын биелэлтийн хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Албан тушаалын үндсэн цалингаас урамшил тооцох хувь (сард)
90-100	Бүрэн хангалттай	15-20 хувь
71-89	Хангалттай	10 хувь хүртэл
71-ээс доош	Хангалтгүй	Нэмэгдэл хөлс олгохгүй.

4.1.Ажлын үр дүн, гүйцэтгэлээр олгох нэмэгдэл хөлс, урамшууллыг дараах тохиолдлуудад ажилтанд олгохгүй.

4.1.1.Үр дүнгийн шалгуурын биелэлт 71 ба түүнээс доош хувьтай үнэлэгдсэн,

4.1.2.Ёс зүйн хэсгийн хорооны хурлаар тухайн улиралд асуудал нь хэлэлцэгдэн, ёс зүйн алдаа зөрчил гаргасан нь тогтоогдсон

4.1.3.Захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулснаас хойш хуанлийн нэг жил буюу шийтгэл ногдуулсан шийдвэрийг гаргасан он сар өдрөөс хойш бүтэн 1 жил өнгөрөх хүртэл хугацаанд үр дүнгийн урамшуулал олгохгүй. (Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 131.4 дэх заалт)

4.1.4.Ээлжийн амралттай, өвдсөн, чөлөөтэй, жирэмсний амралттай, сургалтад суралцаж буй ажилтнуудад тухайн хугацаанд нь үр дүнгийн урамшуулал олгохгүй.

4.1.5.Шинээр ажилд орсон ажилтанд эхний 03 сарын хугацаанд үр дүнгийн урамшуулал олгохгүй.

4.2.Ажиллагсдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг “Бүрэн хангалттай”, “Хангалттай” “Хангалтгүй” гэж үнэлж, улирал бүр дүгнэнэ.

4.3.Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дээрх хувь хэмжээгээр сар бүр мөнгөн урамшууллыг тооцож, дараа улирлын эхний сар дотор багтаан олгоно.

4.4.Холбогдох албан тушаалтнууд ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг сар бүр хийж, улирлын үнэлгээний нэгдсэн дүнг дараа улирлын 10-ны дотор чанарын албанд гаргаж өгсөн байна.

4.5.БОЭТ-ийн ажиллагсад ажлын үр дүн, гүйцэтгэлээр нэмэгдэл хөлс олгоход тавигдах шаардлага, баримтлах зарчим, дүгнэх аргачлал болон бусад холбогдох мэдээллийг нийт ажиллагсад нээлттэй ил тод мэдээлж байна.

4.6.Үнэлгээний дүнг үндэслэн, ажилтнуудад мөнгөн урамшил олгох шийдвэрийг байгууллагын дарга гаргаж хүний нөөцийн албаны дарга тушаалыг боловсруулан тухайн улирлын дараа сарын 12-ны дотор багтаан санхүүд өгнө.

4.7.Ажилтан тус бүрийн ажлыг гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу тасгийн эрхлэгч үнэлэн, авсан оноог ажилтанд танилцуулан гарын үсэг зуруулж, тухайн улирлын дараа эхний сарын 10-ны дотор чанарын албанд хүргүүлсэн байна.

№	Үнэлгээ хийх албан тушаалтан	Үнэлгээ хийлгүүлэх тасаг алба, нэгжийн албан тушаалтан
1	Эмнэлгийн дарга	ЭЗЭДЗ, ТҮАЭДЗ
2	ЭЭДЗахирал	Алдаын дарга нар, тархвар судлаач, тасгийн эрхлэгч нар
3	ЭМТҮЧАБ-ын албаны дарга	Чанарын ажилтан, Чанарын багийн ахлагч
4	ТҮАЭЗ	Инженер техникийн алба
5	Хүний нөөц, сургалт хөгжлийн албаны дарга	Хүний нөөцийн менежер, ажилтан, архивын эрхлэгч, бичиг хэргийн ажилтан, сургалт эрдэм шинжилгээ хариуцсан ажилтан
6	СБАДарга	Нягтлан бодогч, нярав,
7	Эрүүл мэндийн даатгал, статистик мэдээллийн албаны дарга	Эрүүл мэндийн даатгалын их эмч, ажилтан, статистикч эмч, бага эмч, эдийн засагч
8	Сувилахуйн алба	Тасгуудын ахлах сувилагч, аргазүйч, туслах сувилагч
9	Тасгийн эрхлэгч	Өөрийн тасгийн их эмч, сувилагч, үйлчлэгч, үйлчилгээний ажилчид

4.8.Алба, тасгуудын ажлын үр дүн гүйцэтгэлийн үнэлгээг удирдлагын баг 2 хоногийн дотор хянаж үнэлгээг баталгаажуулсан байна.

ТАВ.БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ АЛБАН
ХААГЧДЫН УРАМШУУЛАЛ ОЛГОХ НӨХЦӨЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

№	Албан тушаал	Шалгуур үзүүлэлт
1	Нягтлан бодогч, нярав, бүртгэл тооцооны бусад ажилтан	<ul style="list-style-type: none"> - Улирал, жилийн тайлан тэнцэл, төсвийн төслийг хугацаанд нь үнэн зөв гаргасан байх - Анхан шатны бүртгэл хөтлөлт баримтын боловсруулалтыг тухай бүрт нь хийж, данс бүртгэлд тусгасан байх - Өр авлагын барагдуулалтын байдал - Хөрөнгийн зарцуулалтад тогтмол хяналт тавьж батлагдсан төсвийг хэтрүүлээгүй байх
2	Хүний нөөцийн менежер	<ul style="list-style-type: none"> - Ажилтан нарын хувийн хэргийг тухай бүрт нь нээж, баяжилтыг зохих журмыг дагуу хийсэн байх - Ажиллагчдын цалин хөлс, нэмэгдэлтэй холбогдуулан гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүрт нь авч байх - Ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх талаар идэвх санаачилгатай ажиллаж, үр дүнд хүрсэн байх
3	Архив бичиг хэргийн эрхлэгч, нарийн бичгийн дарга, түүнтэй адилтгах	<ul style="list-style-type: none"> - Бичиг хэргийг эмх цэгцтэй хөтөлж, архивын бичиг баримтыг зохих журмын дагуу хадгалж хамгаалах - Гаднаас ирсэн болон гадагшаа явуулж байгаа бичиг тоотыг тухай бүрт нь бүртгэн авч, хариутай бичгийн гүйцэтгэлд хяналт тавих - Өгөгдсөн үүрэг даалгаварыг тухай бүрт нь хөнгөн шуурхай чанартай гүйцэтгэж байх
4	Жолооч	<ul style="list-style-type: none"> - Өөрийн хариуцаж байгаа машин техникийг ариг гамтай эдэлж, техникийн үйлчилгээг тогтмол хийж байх - Машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж бэлэн байдалд байлгах - Шатахуун, тослох материалыг нормын дагуу хэмнэлттэй зарцуулж, санхүүгийн тогтоосон хугацаанд хийж, замын хуудсыг зохих журмын дагуу хөтөлж байх - Осол гаргаагүй байх
5	Засварчин цахилгаанчин	<ul style="list-style-type: none"> - Эрхэлсэн ажлын чиглэлээр хариуцсан тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хангаж засвар үйлчилгээг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэдэг байх, гарсан эвдрэл гэмтлийг түргэн шуурхай чанартай завсарлаж
6	Харуул, жижүүр, манаач үйлчлэгч, зэрэг бага тушаалын албан хаагч	<ul style="list-style-type: none"> - Ажлын байрны эмх цэгц үлгэр жишээч байж, ариун цэврийн шаардлага хангасан байх - Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил, гомдол гаргаагүй байх - Байгууллагын доторх эд хогшлыг байнга цэвэр үзэмжтэй байлгаж, бүрэн бүтэн байдлыг хангах авсан байх,

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн
захирлын 2026 оны 03 сарын 06 өдрийн
А/24 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



АЛБАН ХААГЧДАД УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ, ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд гүйцэтгэж, байгууллагын зорилго, зорилтыг биелүүлэхэд идэвх санаачилга гаргаж, өгсөн үүрэг даалгаврыг хугацаандаа биелүүлсэн, багаар ажиллах чадвар, өөрийгөө тасралтгүй хөгжүүлсэн байдал, олон нийтийн ажлын оролцоо зэргийг харгалзан ур чадварын нэмэгдлийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж олгоно.

АЖИЛ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮСНЭГТ

№	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо
1	Төлөвлөгөөт ажлын биелэлт	50 оноо
2	Үүрэг даалгаврын биелэлт	10 оноо
3	Олон нийтийн ажилд оролцсон байдал	20 оноо
4	Ажлын цаг ашиглалт	10 оноо
5	Тогтоол шийдвэр, албан бичиг, иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	5 оноо
6	Мэдлэг боловсрол, өөрийгөө хөгжүүлсэн байдал	5 оноо

1.2. Ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингаас тооцож, сар тутам олгож болно.

1.3. Сахилгын арга хэмжээтэй ажилтанд ур чадварын нэмэгдлийг олгохгүй.

1.4. Бусдыгаа манлайлан ажиллаж, эмчилгээ үйлчилгээнд амжилт гаргасан дараах тохиолдлуудад ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 10-25 хувиар тооцон олгоно

1.4.1. Байгууллагадаа өөрийн идэвх санаачилгаар дотоод, гадаадын хөрөнгө оруулалт хийсэн

1.4.2. Эмчилгээ, оношилгооны шинэ дэвшилтэт, үр дүнтэй арга барилыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн

1.4.3. Мэргэжлийн хэвлэлд/өөрийн байгууллагын сэтгүүлээс гадна/ нийтлэл хэвлүүлсэн, грант, төсөл, суурь судалгаа бичиж эрдмийн зөвлөл болон бусад холбогдох зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, бусдыгаа манлайлсан (патент бүхий),

1.4.4.Онцгой байдал, аваар ослын үед онцгой гавьяа байгуулсан, амь тэнссэн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж, хүний амь нас аварсан бол

1.4.5.Улсын хэмжээнд мэргэжлийн болон урлаг спортын уралдаан тэмцээнд 1-3 дугаар байр эзэлсэн амжилтыг үзүүлсэн тохиолдолд тус тус олгоно.



Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын 2026 оны 03 сарын 06 өдрийн А.З.Удугаар тушаалын гуравдугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН-НИЙ АЖЛЫН ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭХ ХҮСНЭГТ

№	Овог нэр	Албан тушаалтан	Ажлын ачаалал, хариуцлага				ЭТҮ-нд оруулсан хувь нэмэр		Тусгай шалгуур үзүүлэлт				Нийт оноо	Үр дүнгийн үнэлгээ	Тооцох хувь	
			Ажлын цаг ашиглалт	Ажлын ачаалал	Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт	Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал	Эрүүл мэндийн даатгалын хасалтын хувь	Чанар сайжруулах талаар санаачилгатай ажиглаж, үр дүнд тооцсон байдал	Ажлын идэвх, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	Эмчилгээ, үйлчилгээний стандартыг мөрдөж байгаа байдал	Халдвар хамраалалын дэглэмийг мөрдөж байгаа байдал	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажигласан байдал				Үр дүнгийн гэрээ, Ажлын байрны тодорхойлолтод зааснаас гадна гүйцэтгэл, чанар
			25	6	6	6	6	8	8	8	8	8	8	100	Бүрэн хангалттай	20%
	Үндсэн шалгуурын оноо															

Ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлсэн Тасгийн эрхлэгч /Албадын дарга/...../нэр/ Хянасан ЭМТҮЧАБА-ны дарга/нэр /

БОЭТ-ИЙН “ЭРҮҮЛ МЭНДИЙН БУСАД АЖИЛТАН”-Ы АЖЛЫН ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭХ ХҮСНЭГТ

.....Тасгийн нэр/онсар.....өдөр

№	Овог нэр	Албан тушаалтан	Ажлын ачаалал, хариуцлага				ЭТҮ-нд оруулсан хувь нэмэр			Тусгай шалгуур үзүүлэлт			Нийт оноо	Үр дүнгийн үнэлгээ	Тооцох хувь	
			Ажлын цаг ашиглалт	Ажлын ачаалал	Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт	Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал	Эрүүл мэндийн даатгалын хасагдлын хувь	Чанар сайжруулах талаар санаачилгатай ажиглаж, үр дүнтэй тоолсон байдал	Ажлын идэвх, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	Стандарт мөрдөж байгаа байдал	Үр дүнгийн гэрээ, Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар	Үндирдлэгээс өрсөн үүрэг даалгаврын биелэлт				
			6	6	6	6	8	8	8	4	10	10	11	100	Бүрэн хангалттай	15%
	Үндсэн шалгуурын оноо		25													

Ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлсэн
 Тасгийн эрхлэгч/Албадын дарга/...../нэр/
 Хянасан
 ЭМТҮЦАБА-ны дарга / нэр/